

ОРЧИН ҮЕИЙН ТОГТМОЛ ХЭВЛЭЛИЙН
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧ ШИНЖИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Н.Ариунзаяа*

* «Отгонтэнгэр» их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D)

Түлхүүр үг: танин мэдэхүй, мэдлэг, гэгээрэл, цогц шинэчлэл, сэтгүүл зүй, уламжлал, туурвил, шинэ нийгэм, шилжилт, сэтгэлгээ, хувьсгалт өөрчлөлт, түүх уламжлал

Монголын ном хэвлэл, нийтлэлийн үнэт уламжлалын нэг нь соён гэгээрүүлэх чиглэл байсан гэдэгтэй хэн ч маргахгүй биз. Тэр уламжлал ардын аман болон бичгийн зохиолоос анхны тогтмол хэвлэлд өвлөгдсөн бөгөөд хувьсгалт хэвлэлийн нийтлэлд шинэ агуулга, сэдвээр баяжин хөгжсөн юм. Харин энэхүү судалгааны ажлыг бичигч миний бие ардчилсан хувьсгалын дараах нийгмийн шилжилтийн зурвас үе буюу ерээд онд тэрхүү уламжлал ямар нэг хэмжээгээр суларсан байх гэсэн таамаглал дэвшүүлээд хэд хэдэн чиглэлээр тандалт судалгаа хийсэн юм.

Тогтмол хэвлэлийн соён гэгээрүүлэгч шинжийг авч үзэхийн өмнө соён гэгээрүүлэх нийтлэлийн шинж чанарыг тодорхойлж, түүний хүрээ хязгаарыг тогтоох хэрэгтэй юм. Юуны өмнө нийтлэлийн соён гэгээрүүлэх шинж гэдэг нь нэлээд өргөн утгатай ойлголт юм. Оросын сэтгүүл зүйн нэрт онолч Е. П. Прохоровын үзж

байгаагаар дэлхий нийтийн соёлын үлгэр жишээ, үнэт зүйлсийг дэлгэрүүлэх замаар хүний бүх талын чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн нийтлэлийн үйл ажиллагаа¹ нь соён гэгээрүүлэх үйл хэрэг болдог байна. Бас сэтгүүл зүй судлаач, доктор М. Зилькафиль «Нийтлэл, нэвтрүүлэг бүхэн уншигч, сонсогч үзэгчдийг танин мэдэхүйн чиглэлд хөтлөн жолоодож, бүх юмны учрыг олох гэсэн хүн төрөлхтний хүсэл эрмэлзэлд тус нэмэр болж байх үүрэгтэй юм. Нийтлэл дэх танин мэдүүлэх элементийн хэрээр уг материалын үнэ цэнг тодорхойлогддог ёс ч бий»² гэсэн нь бидний ойлголттой үндсэндээ дүйж байгаа юм.

Хамгийн товчоор мэдлэг түгээх үйл ажиллагааг соён гэгээрүүлэх хэмээн ойлгож болно. Мэдлэг гэдэг нь хүний танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүнгийн оршин тогтнох ба системчлэгдсэн хэлбэр юм. Хүмүүс өөрийн үйл ажиллагааг зөв зохион байгуулах, түүний явцад үүссэн аливаа асуудлыг шийдвэрлэхдээ мэдлэгийг ашигладаг. Мэдлэг нь өргөн утгаараа төсөөлөл ойлголтын хэлбэртэй бодит байдлын субъектив дүр, явцуу утгаараа тулгарсан зорилтыг шийдвэрлэх бололцоо олгодог шалгагдсан мэдээлэл мөн.

Тэгвэл хүнд хэрэгтэй, урьд өмнө сонсож дуулаагүй шинэ сонин мэдээллээс эхлээд шинжлэх ухааны нарийн ухагдахуун, түүнчилэн хүний мэдлэг туршлага, урлаг гоо зүйн боловсрол, хүмүүжил төлөвшилд тус болох бүх бичлэгийг соён гэгээрүүлэх нийтлэлд хамааруулж болно. Гэвч дэлхий дахины соён гэгээрүүлэх үзлийн түүх, нэрт соён гэгээрүүлэгчдийн үзэл бодол, үйл ажиллагаанаас үзэхэд шинжлэх ухааны мэдлэг түгээх, урлаг уран зохиолын боловсрол олгох явдлыг соён гэгээрүүлэх үйлсийн төвд тавьж иржээ.

Өнөө үед мэдлэгийг баялаг бүтээхээс илүүд үзэн, мэдлэгийн сан хөмрөгийг арвижуулах, түгээх сувгийн хурдыг нэмэх асуудал мэдээллийн нийгмийн чухал зорилт болон дэвшигдэж байна. Мэдээллийн нийгмийн тухай томъёоллыг анх гаргаж ирсэн Японы профессор Ю. Хаяшигийн үзж байгаагаар мэдээллийн нийгмийн үндсэн шинж нь үйлдвэрлэл, технологийн салбарт оюуны өмчийг дээдлэх, нийгмийн үнэт зүйлсийн системд материаллаг зүйлийн үнэлэмж буурах, нийгэм-эдийн засаг, технологийн салбарт мэдлэг мэдээллийг гол үзүүлэлт болгох, соёл боловсролын салбарын үнэлэмж, үйл ажиллагааны зарчим өөрчлөгдөж, хувь хүний ёс суртахуун, оюуны чадамжид тулгуурлах явдал³ ажээ.

Монгол улс дэлхийн хөгжлийн жишгийн дагуу мэдлэгт тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх, хүний хөгжлийн түвшинг дээшлүүлэх үйлсэд татагдан орох нь зайлшгүй юм. Ийм нөхцөлд хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрдэмжүүлэх, өөрөөр хэлбэл соён гэгээрүүлэгч шинжийг гүнзгийрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ шаардлагыг манай тогтмол хэвлэлүүд

хэрхэн хэрэгжүүлж байгааг тодорхойлж, цаашдын зорилт, чиг хандлагын талаар саналаа дэвшүүлэх нь энэхүү бэсрэг өгүүллийн зорилт юм.

Нийгмийн шилжилтийн өмнөх ба дараах үед гарсан Нийгэм-улс төрийн өдөр тутмын гурван сонины нийтлэлд судалгаа хийж үзэхэд өмнөх тогтолцооны үед төлөвшин бүрэлдсэн соён гэгээрүүлэх нийтлэлийн тоо, чанар ардчилсан хувьсгалын дараах үед огцом буурч байгаад сүүлийн жилүүдэд сэргэх хандлагатай байгааг харж болохоор байна. Үүнийг 1985 оны «Үнэн» сонинд нийт материалын 12,0 хувийг эзэлж байсан соён гэгээрүүлэх материалын тоо 1996 оны «Ардын эрх» сонинд 2,0 хувь болтлоо буурч, арав гаруй жилийн дараах «Өдрийн сонин»-д 4,0 хувь болж ялимгүй өссөн дүн харуулж байна.

1990 оны ардчилсан хувьсгал Монгол орны нийгэм, эдийн засаг, эрх зүйн орчинг үндсээр нь өөрчилсний дотор хэвлэл мэдээллийн салбарт ч том хувьсал гарсан. Тэрхүү хувьсал өөрчлөлт бүхэлдээ эерэг үр дүнг авчирсан хэдий ч, бас сүүдэр дагуулж байсан нь нууц биш юм. Нэг талд хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрөөс санхүүжүүлэхийг зогсоосноос болж олон сонин хэвлэл дампуурч байхад, нөгөө талд хүссэн хүн, байгууллага бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүсгэн байгуулах эрхтэй болсноор шинэ сонин хэвлэлүүд “борооны дараах мөөг шиг” олширч байв. Улсын том үйлдвэр, үйлчилгээний газруудыг хувьчилснаас шалтгаалж олон арван мянган хүн ажилгүй болж, зах зээлийн нийгэмд хөлөө олж ядаж байв. Бор хоногийг хэрхэн өнгөрөөх аргаа олж ядаж байсан иргэдэд сонин хэвлэл захиалж унших, театрт очих, кино үзэх нь бараг тансаг хэрэглээ болж байв. Үүнээс

шалтгаалж ерээд онд олон сонин хэвлэл хаагдаж, үзвэрийн газрууд үүдээ барьсан юм. Хэвлэлийн соён гэгээрүүлэх шинж суларсны шалтгаан ч дээрх нөхцөл байдалтай холбоотой байв.

Сонины соён гэгээрүүлэх бичлэгийг тоогоор илэрхийлэх нь харьцангуй ойлголт юм. Тэдгээр материал тухайн сонины нийт нүүр хуудсанд аль хэр зай талбай эзэлж байгаа нь бас нэг үзүүлэлт болно. Тоон үзүүлэлтээр «Үнэн» сонины нийт материалын 12,0 хувийг эзэлж байсан соён гэгээрүүлэх материал тус сонины нийт талбайн 20,0 хувьтай тэнцэж байжээ. Энэ нь ойролцоогоор сонины дөрвөн нүүрийн нэгийг соён гэгээрүүлэх материалаар дүүргэдэг байсан гэсэн үг юм. Нөгөө талаар бас зөвхөн амьдрал ахуйн ашигтай зөвлөгөө, шинжлэх ухаан, техникийн ололт амжилтын мэдээ нийтлэхээр зогсохгүй шинжлэх ухааны тодорхой салбарын онол аргазүй, тулгамдсан асуудал, шинжлэх ухааныг үйлдвэрлэлтэй хослуулах зэрэг асуудлаар сонины "хадаас" материал болохуйц том хэмжээтэй, даацтай өгүүлэл, тайлбар, туршлага нийтэлж байсан нь энэ төрлийн нийтлэлийн эзлэх талбайн хэмжээ ихсэх нөхцөл болсон гэж хэлж болно. Тэгвэл ардчилсан хувьсгалын дараах «Ардын эрх» сонины соён гэгээрүүлэх материалын эзлэх хэмжээ нийт талбайн 4,0 хувь болж унасан бол, 2010 оны «Өдрийн сонин»-д 11,0 хувь болж өссөн байна. Дээрх хоёр янзын судалгааны дүнгээс үзэхэд соён гэгээрүүлэх нийтлэлийн тоо ба талбайн өсөлт, бууралт үндсэндээ нэг чиглэлтэй байна. Энэ нь нийгэм, улс төрийн байдал тогтворжихын хэрээр, иргэд шинэ нийгэмд дасан зохицож, амьдрах аргаа олох тутам гэгээрч соёлжих

хэрэгцээ нь өсдөг, хэвлэл мэдээлэл ч тэр эрэлтийг ямар нэг хэмжээгээр мэдэрч нийтлэлийн бодлогодоо тусгагчийг харуулсан үзүүлэлт юм. Ерээд онд нэг талд улс төрийн тогтворгүй байдлаас болж ард иргэдийн сэтгэл санаа тавгүйтэн, айж эмээх, эргэлзэж тээнэгэлзэх сэтгэлгээнд автаж, нөгөө талд улсын үйлдвэр, аж ахуйн газруудад ажиллаж байсан олон арван мянган хүн ажилгүй болж, өдөр тутмынхаа амьдралыг хэрхэн залгуулах учраа олохгүй байсан нь сонин хэвлэлийн нийтлэлийн соён гэгээрүүлэх шинж саарч, үзвэр үйлчилгээний газрууд үүдээ барих шалтгаан болж байжээ.

Соён гэгээрүүлэх нийтлэлийн байдлыг ярихад зайлшгүй анхаарч үзэх зүйлийн нэг нь энэ чиглэлийн нийтлэлийн бүтцийн тухай асуудал мөн. Судалгаанд хамрагдах хугацаанд соён гэгээрүүлэх материалын агуулга, бүтцэд ихээхэн өөрчлөлт гарчээ. Энэ нь нийгмийн ертөнцийг үзэх үзэлд гарсан өөрчлөлттэй ихээхэн холбоотой байна. Тухайлбал наяд оны «Үнэн» сонины соён гэгээрүүлэх нийтлэлийн ихэнхийг олон улсын амьдрал, шинжлэх ухаан танин мэдэхүйн сэдэвт материал эзэлдэг байсан бол урлаг, уран зохиол удаалж, соёл зан заншил, ашигтай зөвлөгөө, түүх уламжлалын сэдэв бага хэмжээтэй тусгагддаг байжээ. Хоёр системийн үзэл суртлын тэмцэл хурцдаж байсан үед «Үнэн» сонин дөрөвдүгээр нүүрээ бүхэлд нь олон улсын амьдралд зориулж олон улсын тойм, тайлбар, өгүүлэл, мэдээ зэрэг бичлэгийн олон хэлбэрийг ашигладаг байжээ. Тэдгээрийн дотор социалист системийн давуу талыг сурталчилж, хөрөнгөт ертөнцийн нүүр царайг илчлэхэд чиглэсэн материал зонхилж

байсан байна. Ерээд оны «Ардын эрх» сонинд олон улсын амьдрал, соёл зан заншил, түүх уламжлалын сэдэв түлхүү гарч, шинжлэх ухаан танин мэдэхүй, уран зохиол, урлагийн сэдэв эрс буурсан байна. Энэ нь улс төрийн учир шалтгаантай байжээ. Тухайлбал энэ үед урьд нь хөрөнгөтөн гэгдэж байсан зах зээлийн орнуудын туршлагыг авах явдал чухал болсонтой холбоотойгоор «Ардын эрх» сонинд тэдгээр орнуудад эрх зүйт төрийг хэрхэн төлөвшүүлсэн, өмчөө яаж хувьчилсан, сонгуулийн систем нь ямар давуу талтай болох, бизнесийн орчинг яаж бүрдүүлдэг гэх мэт олон сэдвээр туршлага, өгүүлэл, тайлбар нийтэлж байжээ. Коммунист сэтгүүл зүйн үед түүхэн уламжлал, хуучны соёл, зан заншлын сэдэвтэй нийтлэл харьцангуй цөөн гарч байв. Энэ нь дээрх сэдвийг хөндөх бүрд "феодалын соёл"-ыг магтаж, "үндэсний үзэл" цухалзуулсан хэрэгт холбогддогтой холбоотой байсан юм.

Ерээд оноос шинэ нийгэмд шилжиж, үзэл суртлын хориг тавигдсантай холбоотойгоор түүх уламжлал, соёл, зан заншлаа эргэж харах, өвлөж авах, ялангуяа цагтаа дэлхийн улс төр, оюун санааны төв болж байсан монгол төрийн мэргэн бодлогоор бахархах, түүнд авах гээхийн ухаанаар хандахад чиглэсэн материал элбэгшсэн байна

«Ардын эрх»-д 26,0 хувийг, «Үнэн»

сонинд 7,0 хувьтай байсан соёл, зан заншлын сэдэв «Ардын эрх»-д 27,0 хувийг тус тус эзлэх болсноор тайлбарлаж болно. Мөн ерээд онд хамгийн их буурсан сэдвийн нэг нь шинжлэх ухаан, танин мэдэхүйн сэдэв байжээ. «Үнэн» сонинд нийт материалын 28,0 хувийг эзэлж байсан энэ сэдэв «Ардын эрх» сонинд 3,0 хувь болтлоо буурсан юм.

Гэтэл 2010 он болоход тогтмол хэвлэлийн соён гэгээрүүлэх чиглэлийн материалын хэмжээ ерөнхийдөө өссөн

ний дотор шинжлэх ухаан, танин мэдэхүй, амьдрал ахуйн ашигтай зөвлөгөө нийтлэх хэмжээ «Ардын эрх»-тэй харьцуулахад эрс өссөн байдал ажиглагдаж байна. Тухайлбал «Ардын эрх»-д нийт материалын 3,0 хувийг эзэлж байсан шинжлэх ухаан, танин мэдэхүйн

сэдэвт нийтлэл «Өдрийн сонин»-д 23,0 хувь болтлоо өссөн байна. Түүнчилэн урлаг, уран зохиолын сэдэвт материал «Ардын эрх»-ийнхээс 14,0 хувиар өссөн нь эерэг үзүүлэлт мөн. Судалгаанд хамрагдсан хугацаанд тогтмол хэвлэлийн соён гэгээрүүлэх материалын бүтэц хэрхэн өөрчлөгдсөнийг дараах графикаас харж болно.

Хүн төрөлхтний харилцах, мэдлэг мэдээлэл дамжуулах үйл явц дөрвөн том үе шатыг дамжиж өнөө үед хүрч ирсэн байна. Энэ нь хэл яриа үүссэн, бичиг үсэг зохиож хэрэглэсэн, ном хэвлэл үйлдэх болсон, орчин үеийн мультимедиа техник, компьютерийн эрин үе эхэлсэн зэрэг болно.

Харилцааны эдгээр үе шатууд нь хүний нийгмийн хөгжил хийгээд баялаг бүтээх үйл явцад өөрчлөлт гаргаж, оюуны хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэж иржээ.

Хүн төрөлхтөн бараг дөрвөн зуун жилийн өмнө олж илрүүлсэн мэдлэг дамжуулах арга техникээ XX зууны дунд үеийг хүртэл огцом өөрчилж чадаагүй боловч бага багаар боловсронгуй болгосоор байжээ. Дурдан бүхий үед мэдлэг дамжуулах арга шинээр нээгдээгүй боловч түүнийг дамжуулах хурд эрс нэмэгдсэн байна. Энэ үед мэдлэгийг бүтээх тусгайлсан бүтэц буюу Их сургуулиуд хөгжиж, мэдлэгийн төлөө ажилладаг мэргэжил буй болсон нь дэлхий дахины мэдлэгийн сан хөмрөг нэмэгдэхэд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Үүнээс өмнө мэдлэг зөвхөн практик үйл ажиллагаагаар дамжин амьдралын үйл явц, туршилтын үр дүнд бүтээгддэг байсан бол, XVII-XVIII зуунд шинжлэх ухааны салбарууд үүсч хөгжсөнөөр мэдлэгийг онолоор бүтээх хөдөлмөрийн шинэ хуваарийг буй болгожээ.

Мэдлэгийг шууд дамжуулах уламжлалт аргаас шууд бус аргаар мэдээлэл дамжуулах, уламжлах арга ухаанд шилжиж байгаа нь өнөө үеийн соён гэгээрүүлэх үйлсийн нэг онцлог болж байна. Энэ арга нь мэдээлэл харилцааны ололтод шууд тулгуурладаг, өөрөөр хэлбэл ном, тогтмол хэвлэл, дүрс, дуу бичлэг, мульти медиа хэрэгслийг ашиглах замаар мэдээлэл дамжуулдаг онцлогтой юм. Мэдээлэл харилцааны хөгжил нь илүү их мэдлэгийг хурдан түгээх, найдвартай хадгалах, уламжлан хөгжүүлэх өргөн боломж олгож, мэдлэг дамжих хурдыг үлэмж нэмэгдүүлсэн байна. Улмаар мэдлэг дамжуулах үйл явцад математик тооцооллыг хэрэглэснээр мэдлэг цэгцэрч,

мэдээллийн утга улам гүнзгийрэх болов.

XXI зууны иргэд мэдлэг дамжуулах мульти медиа хэрэгслийн эринд аж төрж байна. Хүн төрөлхтөн хэл яриа, ном зохиол, боловсролын тогтолцоо зэрэг мэдлэг дамжуулах уламжлалт аргын зэрэгцээгээр илүү хурдтай, бүтээмж өндөртэй аргуудыг эзэмших болов. Энэ ололтын эх суурь XX зуунд тавигдсан юм. Өнгөрсөн зуунд хүн төрөлхтний мэдлэгийн сан хөмрөг олон шинэ зүйлээр баяжиж, шинжлэх ухааны шинэ шинэ салбар үүсэн хөгжив. Тухайлбал цөмийн энергийг олон салбарт ашиглаж, сансрын уудмыг шинжилж, генетикийн нууцыг нээсэн байна. Компьютер нийтийн хэрэглээ болсноор харилцааны илүү цогцолбор, хурдтай арга замыг нээж, мэдлэг дамжуулалт эрчимжив. Ийм нөхцөлд мэдлэг ухааныг дээдэлсэн нийтлэлийн бодлого барьж ажиллах нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн үүргээ хэрхэн биелүүлж байгаагийн нэг үзүүлэлт болно. Ялангуяа сонин, сэтгүүл мэт уламжлалт хэрэгслүүдийн хувьд гэгээрүүлэгч шинж онцгой чухал болж байна. Өнөөгийн хүмүүсийн амьдралд нэвтэрч байгаа электрон мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэл дамжуулах хурдыг гүйцэхгүй нь тодорхой болсон тогтмол хэвлэлүүд гагцхүү оюунлаг, гэгээрүүлэгч шинжээрээ орон зайгаа хадгалж үлдэх боломжтой юм. Соён гэгээрүүлэх нийтлэлийн асуудлыг авч үзэхэд уншигчдын эрэлт хэрэгцээг судлах шаардлага зайлшгүй гарч ирнэ. Өөрөөр хэлбэл энэ чиглэлийн нийтлэлийг уншигчид хэр зэрэг хүсч хүлээж байна вэ, тэр хэрэгцээг сонины нийтлэл хэрхэн хангаж байна вэ? гэдэг асуудалд хариу олох хэрэгтэй болно. Энэ зорилгоор сонин уншигчдын эрэлт хэрэгцээг судалж үзсэн юм.

Судалгааны дүнгээс үзэхэд шинжлэх ухааны мэдээлэл, уран зохиол, амьдрал ахуйд ашигтай зөвлөгөө, олон улсын амьдрал зэрэг мэдлэг ухааны шинжтэй материалыг нийт уншигчдын 40,0 хувь нь хүсэн хүлээж байдаг аж. Гэтэл өнөөдөр гарч байгаа «Өдрийн сонин»-ы соён гэгээрүүлэх шинжтэй материал тус сонины нийт материалын дөнгөж 11,0 хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн хэлээр бол нийлүүлэлт нь эрэлтээсээ хоцорч байгааг харуулж байна.

Соён гэгээрүүлэх чиглэлтэй материалын дотор дэлхийн хүн ардын аж амьдрал, соёл, зан заншил, амьдрал ахуйд ашигтай зөвлөгөө багагүй зай талбай эзэлдэг байна. Ерээд оны «Ардын эрх» сонин ийм чиглэлийн материалыг маш товч бөгөөд жижиг булангийн хэлбэрээр өгдөг нь бараг дугаар бүрд гардаг «Мэдэхэд илүүдэхгүй», «Сониуч үзгээр», «Дуулгах сонин», «Сонирхуулахуй», «Та өөрөө оточ», «Онигоо» гэх мэт хөмсөг гарчгийн дор нийтэлсэн материалуудаас тодорхой харагддаг. Тус сонинд бас Ж. Мягмарсүрэнгийн «Гахайн сүргийн гашуудалт дуун» (1996.4.26), Б. Цэрэнгийн «Хөлдөхөөс хэрхэн хамгаалах вэ?» (1996.1.18), З. Түмэнжаргалын «Эгшиг дуу дагасан эсэг бусад бодол» (1996.1.12), "TIME" сэтгүүлээс орчуулсан «Уэльсийн хунтайж нарын хувийн амьдралд хатан хаан их нөлөөтэй» (1996.1.13), Т. Хандын орчуулсан «Гарри Каспаров: Би үхээд сэхлээ» ярилцлага (1996.1.13), «Д. Өлзийсайхан: Сонгодог урлагийг үнэлэх цаг ойрхон» ярилцлага (1996.1.12), гэх зэрэг соён гэгээрүүлэх шинжтэй нийтлэлүүд гарсан байна.

Тухайлбал «Гарри Каспаров: Би үхээд сэхлээ» гэсэн гарчигтай ярилцлагад сэтгүүлч шатрын ертөнц хийгээд

дэлхийн шатрын 13 дахь аваргыг тойрсон хамгийн сонирхолтой байж болох асуултуудад хариу авч чадсан нь уг нийтлэлийн соён гэгээрүүлэх шинжийг өргөсөн байна. Ялангуяа манай гаригийн хамгийн дуулиантай шатарчин гэгддэг Каспаровын өвөрмөц сэтгэлгээ, этгээд зан чанарыг гаргаж чадсан нь сонирхол татдаг. Жишээ нь:

- Хэрвээ Фишер ч юм уу, үгүй бол Капабланка өнөөдөр тогловол таныг хожиж чадах уу? гэсэн асуултад Каспаров,

- Дэмий юм болно. Далан хоёр оны загварын Фишер өнөөдөр тоглох юм бол дэлхийн аварга байтугайд нь хожигдох нь мэдээж. Түүний хувьд өнөөгийн шатар өөр ертөнцийн тоглоом шиг л санагдана байх. Өнөөгийнх шиг шатрын асар их мэдээллийн баазыг өнгөрсөн үеийн дэлхийн аваргууд зүүдэлж ч байгаагүй юм шүү гэж хариулжээ. Тэрбээр бас,

- Таныг нэг удаа компьютерт хожигдож байсныг санаж байна. Энэ үед танд ямар сэтгэгдэл төрсөн бэ? гэж асуухад,

- Хожигдохыг би үзэн яддаг хүн! Компьютерт би тэнэгээсээ болж хожигдсон бөгөөд одоо ч түүндээ уур багтарч явдаг. Ер нь компьютер дэлхийн аваргыг хэзээ ч хожих үндэсгүй. Хождог юм гэхэд 1-2 өргөөс хэтрэхгүй гэсэн бол,

- Дээд зиндааны ихэнх тамирчид өрсөлдөгчөө үзэн ядах нь ялалт байгуулах эх сурвалж гэж үздэг. Та бас ийм үзэл бодлыг эрхэмлэдэг үү? гэхэд,

- Үүнтэй чинь санал нийлэхгүй байна. Гэхдээ тоглож байх үед өрсөлдөгчөө хамгийн дорой амьтан хэмээн бодож, түүний толгой дээр энэ ертөнцийн хамаг гай зовлонг үүрүүлмээр санагдах үе байдаг. Энэ бол түр зуурын л юм даа гэх мэт олон сонирхолтой зүйлийг ярьсан байна.

Байгаль ертөнцийн зүй тогтлыг танин мэдэх, түүний нууцад нэвтрэх, хүн хийгээд ургамал, амьтны экологийн тухай мэдлэг олж авах нь соён гэгээрэхийн нэг бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ сэдвээр бичдэг сэтгүүлчдийн нэг нь Ж. Мягмарсүрэн юм. Тэрбээр «Гахайн сүргийн гашуудалт дуун» гэдэг нийтлэлээ үлэмж сонирхолтой бичжээ. Сэтгүүлч, гахайн амьдралын орчинг «Зэрлэг гахай ойтой нутгийн амьтан. Ургамлын үндэс, самар жимс, элдэв жижиг мэргэчид, ер нь юу тааралдсанаараа хооллодог. Өчүүхэн чийгийн улаан хорхой идэх гэж ээтгэр хоншоороо гэдийтэл газар ухна. Тийнхүү хөдөлмөрлөж байж бөмбийлтөө таргална. Таргалахгүй бол болохгүй. Үсгүй шахам нүцгэн амьтныг өвлийн жавраас өөх нь хамгаалдаг билээ. Бурхан түүнд “үс өгөхгүй, өөх өгье” гэж айлдсан бололтой» гэж дүрсэлсэн бол, хэрхэн өсч үрждэг тухайд «мэгж зуны эхээр төллөнө. Гэнэтхэн л нэг өдөр ааш нь хувирч жижиг багачуулынхаа чихийг хазан орилуулж байснаа цүдгэнээд алга болдог. Тэр, долоо хоногийн дараа шуугиж шаагисан сүрэг болоод буцаж ирнэ. Торойныхоо тоотой тэнцүү унжсан ягаан хөхөөрөө цэцэг гуядсан шолбойсон амьтан болчихсон байна. Торойны эндэгдэл их.

Чоно торойг нь мэгжнээс тун зальжин салгана гээч. Хоёр чоно хоёр талаас нь ээлжилж довтолно. Мэгж торойнуудаа гэдсэн дороо хурааж хамгаалалтад орно. Нэг чоно урдаас нь дайрна. Мэгж бас урдаас нь ухасхийнэ. Тэр үед ард байгаа чоно нэг торойг нь үмхээд дуугүй болгочихно. Дараагийн ээлжинд ардах чоно довтолно. Мэгж өөдөөс нь дайрна. Үлдсэн чоно бас нэг торой зуугаад авна. Энэ мэтчилэнгээр түүчихдэг» гэх мэтээр зэрлэг гахайн

амьдралыг яг л хүний амьдрал тэмцэлийг бичиж байгаа шиг нэн уншууртай бичсэн байна. Соён гэгээрүүлэх нийтлэлийн эцсийн зорилго нь хүнд мэдлэг эзэмшүүлэх явдал юм. Мэдээллийн суваг олширсонтой холбоотойгоор өнөөгийн хүмүүс цаг зарж, сонины хуудсыг удаан шагайж мэдлэгээ зузаалахын оронд телевиз болон бусад хэрэгслийг босон суун үзэх, сонсох замаар мэдлэг мэдээлэл олж авахыг илүүд үзэх хандлагатай болсон байна. Ийм нөхцөлд сонины соён гэгээрүүлэх материалд шинжлэх ухааны үнэнээс гадна илэрхийлэх арга, ур чадвар чухал болж байна. Энэ нь уншигчийг нийтлэлтэй уях найдвартай арга мөн. Ж. Мягмарсүрэн амьтдын тухай тэмдэглэлийн хоёр ч ном бичиж тийнхүү өөрийн номтой уншигчийг “барьж уях” үлгэр жишээг харуулсан сэтгүүлч юм.

Яруу найрагч З. Түмэнжаргал «Эгшиг дуу дагасан эсэг бусад бодол» гэдэг өгүүлэлдээ «"Дуу хэмээх нь гурван жигүүртэй шувуу". Манай нэгэн нэрт яруу найрагч ингэж хэлсэн. Тэрхүү гурван жигүүр хэмээгч нь шүлэг, аялгуу, дуучин гурав бөлгөө. Чингэтэл бас ачир дээрээ бол дууг ер дуучинд зориулж зохиодоггүй, дуулагч хүмүүст зориулж туурвидаг. Манай хүүхдийн дууны хөгжмийн зохиолч Л. Галмандах нэгэнтээ "миний дуунуудыг хэзээ ч, ямар ч гавьяат дуулаагүй. Дандаа л дунд сургуулийн нусгай хүүхдүүд дуулсаар нийтэд түгээсэн" гэж ярьж байсныг санаж байна. Нээрээ л тийм дээ» гэхчилэн бичээд дуунд шүлэг анхдагч болох тухай, дууны шүлэг болон аяыг зохиогчид үргэлж “хөшигний ард” үлдэж, нэг ёсондоо дуучдад хөдөлмөрөө мөлжүүлж байгаа тухай, уг асуудлыг зохиогчийн эрхийн хуулиар зохицуулах цаг болсон тухай зэрэг тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавьжээ.

Хямралын хүнд үе байсан, хүн ард гэгээрлийг эрхэмлэх сөхөөгүй явсан ерээд онд гарч байсан «Ардын эрх» сонин хааяа «Соёл урлаг»-ийн нүүр гаргаж, түүндээ уншигчдын урлаг, гоо зүйн боловсролыг ахиулахад чиглэсэн зүйл нийтэлж байсан нь олзуурхуштай хэрэг байв. Тус сонины 1996 оны нэгдүгээр сарын 12-ны дугаарын «Соёл, урлаг»-ийн нүүрт Сонгодог урлагийн академик театрын балетмейстер Д. Өлзийсайхантай хийсэн ярилцлагыг нийтэлжээ. Уг ярилцлагад Д. Өлзийсайхан «Балетмейстерийн ажил театрын бусад найруулагчдынхаас хамаагүй хэцүү. Зохиолоо уншсаныхаа дараа бүжгийн хөдөлгөөнөөр илэрхийлэхийн тулд шинэ цомлол бичнэ. Тэр цомлолоо хөгжмийн зохиолчид өгч хөгжмийнх нь аяс төрхийг тааруулна. Бэлэн сэдэв, хөгжим байлаа гэхэд бүжгийн хөдөлгөөнөө түүнд нийцүүлэн зохионо. Ингэж цомлол, сэдэв, хөгжим, бүжгээ бүгдийг нэг мөр болгосныхоо дараа найруулагчийн ажлаа эхэлнэ» гэх буюу «Миний “Гэгээн хаврын ёслол” хямдхан боссон. 400-500 мянган төгрөг хавьд бүтсэн. “Баядерз” зургаан саяд боссон. Сонгодог балет болохоор тайз чимэглэл гээд зардал ихтэй. Модерн балет хувцас хунараар биш, хийсвэрлэл, биеийн хөдөлгөөнөөр санаагаа хэлдэг болохоор зардал бага. Тэгэхдээ найруулахад модерн нь хэцүү» гэх мэтээр ярьсан нь сонгодог урлагийг ойлгоход тустай зүйл болжээ. Гэвч ерээд оны «Ардын эрх» сонинд энэ мэт гэгээрүүлэх шинжтэй нийтлэл ховорхон үзэгдэж байгаа нь тухайн цаг үеийн байдал, амьдралын нөхцөлтэй холбоотой байжээ. Бухимдлаар дүүрэн байсан нийгэмд гэрэл гэгээтэй нийтлэл байнга гардаггүй, тийм бичлэгийг унших эрэлт ч бага байжээ.

Шинэ зууны тогтмол хэвлэлд соён гэгээрүүлэх шинжтэй нийтлэлийн тоо, хэмжээ аажмаар өсч байгаа нь бидний судалгааны нэг зэрэг үзүүлэлт юм. Өнөөгийн «Өдрийн сонин» соён гэгээрүүлэх нийтлэлийн бодлогоо харьцангуй бие даасан томоохон бичлэгээр шийдвэрлэдэг болсон онцлог ажиглагдаж байна. Жишээ нь Д. Оюунтуяагийн «Мянган улаан атаа авчраад нүүлгээд явна гэсэн яалаа» На. Сүхбаатартай хийсэн ярилцлага (2010.1.15, №011), Т. Гэрэлмаагийн «Монголын эрдэмтэд гар утаснаасаа удирддаг гэрийн халаагуур зохион бүтээжээ» Б. Чадраатай хийсэн ярилцлага (2010.1.14, №010), Б. Баабарын «Хамо Наурус» (2010.1.06, №003), Х. Батын «Хувьцаа хэрхэн мөнгө болдог вэ?» (2010.1.04, №001), Г. Жамьянгийн «Зая бандид гэгээний хонин гартаа хөөрөг ч бий» (2010.1.21, №016), Ш. Батмөнхийн «Торсион орон хийгээд хуурамч шинжлэх ухаан» (2010.1.20, №015), Д. Цогзолмаагийн «Сүрьеэгийн өвчлөлд агаарын бохирдол нөлөөлдөг» (2010.1.4), Н. Пагмын «Дэлхийн улс төрийн золиос Пергамоны их шүтээн» (2010.1.7), «Ашурбанипал хааны их ав» (2010, №12), Б. Цэмбэлийн «Газар хөдлөхийг урьдчилж мэдэх боломжгүй» (2010, №12) зэрэг даацтай нийтлэл олон гарсан байна.

Тус сонины соён гэгээрүүлэх шинжтэй материалуудыг ерөнхийд нь олон улс, дэлхий ертөнцийн сонин, улс төр, эдийн засгийн сэдэвтэй өгүүлэл, шинжлэх ухааны ололт амжилт, суут хүмүүс, эрдэмтэн мэргэдийн амьдрал хөдөлмөр, түүх, угсаатны зүйн асуудал, урлаг, уран зохиол, шинжлэх ухааны шинэ мэдээ, амьдрал ахуйн ашигтай зөвлөгөө бүрдүүлж байна.

«Өдрийн сонин»-д нийтлэгдсэн «Хувьцаа хэрхэн мөнгө болдог вэ?»

гэдэг өгүүлэл иргэдийн өнөөг хүртэл бүрэн ойлгохгүй явж ирсэн хувьцааны тухай өгүүлснээрээ амьдрал ахуйд ашигтай нийтлэл болжээ. Нийтдээ арван жижиг хэсгээс бүрдэх энэ өгүүллийн «Хувьцаа гэж юу вэ?» гэсэн хэсэгт «Компанид хүмүүс хөрөнгө оруулдаг бөгөөд арилжаалагдсан хувьцаа нь тухайн компанийн хөрөнгө оруулалт болдог. Хувьцаа нь хувьцаат компаниас гаргасан тухайн хувьцаа эзэмшигчийн нэр бүхий хувьцааны гэрчилгээгээр баталгааждаг бөгөөд уг гэрчилгээ нь тухайн хувьцаа эзэмшигч хэдэн хувьцаа эзэмшиж байгаа болон тухайн компанийн хөрөнгийн нэгээхэн хэсгийг өмчлөгч болохыг батлах хууль зүйн баримт бичиг болдог» хэмээн тайлбарласан бол, «Хувьцаагаар яаж ашиг олдог вэ?» гэсэн хэсэгт «Нээлт-тэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авч байгаа хүн хоёр байдлаар ашиг олж болно. Нэгд: компани ашиг олсон тохиолдолд тухайн ашгийн тодорхой хэсгийг хувьцаа эзэмшигч ногдол ашиг хэлбэрээр хүртдэг. Хоёрт: компани ашиг олоогүй, эсвэл ногдол ашиг хуваарилах хэмжээнд хүрээгүй нөхцөлд хувьцаа эзэмшигч тухайн хувьцааны анхлан худалдаж авсан үнийн өсөлтөөс ашиг олж болдог» гэх мэтээр тайлбарлан бичсэн байна. Мөн өгүүлэлд хувьцаа болон зээлийн санхүүжилт, хувьцааг үнэлэх журам, худалдан авахад анхаарах зүйл, хөрөнгийн бирж гэж юу болох зэргийг нэн ойлгомжтой өгүүлжээ.

«Монгол эрдэмтэд гар утаснаасаа удирддаг гэрийн халаагуур зохион бүтээжээ» гэсэн гарчгийн дор манай физикч эрдэмтдийн бүтээсэн алсын удирдлагатай гэр халаагчийн талаар ШУА-ийн физик технологийн хүрээлэн-гийн захирал, академич Б. Чадраатай хийсэн ярилцлагыг нийтэлсэн байна. Уг

ярилцлагад Б. Чадраа «Бид цахилгаан хэмнэдэг төхөөрөмж хийе, тэгээд тэр хэмнэсэн цахилгаанаараа айлуудыг халаа гэж үзсэн. Тэгээд хэд хэдэн хувилбар боловсруулж, түүний дотроос нэгийг нь сонгон аваад нэлээд хэдэн газарт туршиж үзсэн. Энэ нь гэрт хоёр кв цагийн хүчин чадалтай цахилгаан зарцуулна. Шөнийн цаг буюу цахилгааны үнэ хямд үед энэхүү тоног төхөөрөмж маань бүрэн хүчин чадлаараа ажиллах нь цахилгаан арай их хэрэглэнэ гэсэн үг юм. Шөнийн турш хэрэглэсэн ч цахилгааны үнэ хямд учир асуудал гарахгүй. Харин өдрийн цагаар уг төхөөрөмжид тохируулга хийж болдог. Эзгүй үедээ унтраахчаа, гэртээ ирж явахдаа асаачихна. Гэрийн эзэн хаана ч явсан гар утсаараа төхөөрөмжийг удирдана. Унтраах, асаах, дулааныг нэмэх, хасах зэргээр хүссэнээ хийж болно. Ингэж тохируулга хийснээр цахилгаанаар ажилладаг бусад төхөөрөмжүүдийг бодвол бараг 60 хувиар цахилгаан хэмнэдэг нь тогтоогдсон» гэх мэтээр ярьсан нь Нийслэлийг утаанаас нь салгах оновчтой аргыг санал болгосон үр өгөөжтэй яриа болсон байна.

«Өдрийн сонин» нийтлэлч Баабарын «Хомо наурс» гэдэг өгүүллийг нийтэлжээ. Уг өгүүлэлд дэлхийн хамгийн жижигхэн улсын тухай өгүүлсэн байна. «Науру гэж нэгэн арлын жижиг улс гадаад далайд байх юм. Газар нутаг нь 21 ам. километр гэхээр хааш хаашаа 4-5 километр болж таарах нь. Хүн амын хувьд дэлхийд хамгийн бага буюу ердөө 10 мянга хүрэхгүй иргэнтэй. Хүн амд ноогдох орлогын хувьд дэлхийн хамгийн баян орны нэг. Үүний цаад шалтгаан нь арал тэр чигээрээ маш өндөр концентрацитай фосфор юм. Хүн амын 80 хувь нь уугуул иргэд, 1968

онд тусгаар тогтносон» гэх мэтээр бичсэн нь уншигчдын танин мэдэхүйд тустай зүйл болсон байна. «Өдрийн сонин»-д бас доктор Ш. Батмөнхийн «Торсион орон хийгээд хуурамч шинжлэх ухаан» (2010, №15), эдийн засагч Б. Лхагважавын «Мөнгөний амлалт зогсохгүй бол банкны зээлийн хүү буухгүй» (2010, №16), сэтгүүлч Г. Жамьянгийн «Зая бандид гэгээний хонин гартаа хөөрөг ч бий» (2010, №17) гэх зэрэг сонирхолтой нийтлэлүүд гарчээ.

Эртхэндээ Баруун Монголын хүн амын ихэнхийг бүрдүүлж байгаад эдүгээ Ар, Өвөр Монголын нутагт тарж суурьшсан өөлдүүдийн угсаа гарвал, түүх намтрыг түүхч На. Сүхбаатараар яриулж авснаа сэтгүүлч Д. Оюунтуяа «Мянган улаан атаа авчраад нүүлгээд явна гэсэн яалаа» гэсэн гарчигтайгаар маш сонирхолтой зохиомжлон бичсэн байна. «Өдрийн сонин» бас Турк улсад хүн дүрстэй ишиг төрсөн тухай, тус улсад болсон нэгэн ер бусын уулзалтын хамгийн өндөр зочин 2,46 м, харин хамгийн намхан нь 70 см байсан зэрэг сонирхолтой баримтуудыг нийтэлжээ.

Энэхүү өгүүллийг тэрлэгч миний бие нийгмийн хамгийн өргөн давхаргад хүрч чаддаг, олон уншигчтай үндэсний хэмжээний гурван сонины соён гэгээрүүлэх нийтлэлийн залгамж шинжийг судалгааныхаа үндсэн хэрэглэгдэхүүн болгосон билээ. Энэ нь төлөөллийг оновчтой сонгох санаа болохоос биш, бусад тогтмол хэвлэлд оюунлаг нийтлэл байхгүй гэсэн хэрэг хараахан биш билээ. Тогтмол хэвлэлийн соён гэгээрүүлэгч шинжийг ярих үед эрдэмтэн зохиолч Л. Түдэвийн эрхлэн гаргадаг «Дал» сонины тухай дурдахгүй өнгөрч болохгүй. Шилжилтийн эхэн үед «Үндэсний соёлын зам», «Арга билэг», «Түмэн

бодис», «Урлах эрдэм», «Номын ертөнц», «Зохист аялгуу», «Сэтгэмж», «Соёл эрдэнэ», «Онгод», «Билгийн толь», «Хойчийг залгамжлагч», «Алтан хүрдэн», «Эрд-мийн далай», «Монгол шатар», «Дэлхийн мэдээ» зэрэг гэгээрүүлэх шинжтэй олон сонин гарсан боловч уншигчгүйн улмаас гаралтаа зогсоосон байдаг. Харин «Дал» сонин өнөөг хүртэл гарч байгаа нь нэгд: нийтлэлийн чанар, хоёрт: зөв менежментийн үр дүн юм. Уг сониныг ганц хүний эрхэлсэн шинжлэх ухаан, танин мэдэхүйн чөлөөт сонин гэж тодорхойлж болох бөгөөд улс төрийн аливаа үзэл бодлоос ангид, зөвхөн эрдэм ухаан түгээх чиглэлийг хатуу барьдаг хэвлэл юм. Эдүгээ 300 гаруй дугаар гаргаад байгаа энэ сонины газраас бас «Далыг далуулаа!» гэдэг дагуул товхимол гаргадаг билээ. Дугаар бүрийнхээ эхэнд «Хонины баруун хаанаас мөчийг аваад ирээдүйг таалгахаар ховх ялзарч, далны нь ясыг мултарч гартал сайн чанаад, ховсчинд түүнийг шинжлүүлэн үзүүлэхийн цаг дор, хол ойрын явдал хэргийг тааварлан мэддэгсэн билээ» гэсэн Майкл Дрейтоны үгийг титэм болгож бичдэг энэхүү товхимлын дугаар бүр нь шинжлэх ухаан, түүх, соёл, зан үйлийн аль нэг сэдвээр дагнан гардаг байна. Жишээ нь 2001 оны №14 (2) нь монгол малын тамганы тухай цуврал өгүүлүүдээр, 2002 оны №20 (4) нь Монгол төрийн туг сүлдний тухай цуврал өгүүлэл, зургуудаар, 2006 оны №33 (1) нь хүмүүнжихүйн сэдэвт өгүүлүүдээр тус тус дагнан гарсан байх жишээтэй. Л. Түдэвийн «Дал» сониныг олон талт мэдлэгийн «архив» гэж хэлж болох бөгөөд юм бүхнийг зоосны нүхээр хардаг өнөө үед нийгмийн гэгээрлийн төлөө тогтмол хэвлэл гаргаж, түүгээрээ уншигчдын

сонирхлыг татаж, оюунлаг хэрэглэгчдийн хүрээг буй болгож болдгийг харуулсан сайхан жишээ мөн. Сүүлийн жилүүдэд өдөр тутмын сонинуудын нийтлэл ерөнхийдөө төлөвшиж, оюунлаг нийтлэл сэргэх хандлагатай байгаа боловч байнга өсөн нэмэгдэж байгаа уншигчдын оюуны эрэлт хэрэгцээг гүйцэж чадахгүй байгааг судалгааны дүн харууллаа.

Нийтлэлийг соён гэгээрүүлэгч шинжтэй болгоход тогтмол хэвлэлийн уламжлалт хэлбэр болох сэтгүүл чухал үүрэгтэй билээ. Сэтгүүлийн соён гэгээрүүлэх шинж сониныхоос давуу байдаг нь өдөр бүр гардаггүй учир байгал нийгмийн үзэгдэл, үйл явдлыг тал бүрээс нь ул суурьтай судалж, гүнзгий дүгнэлт хийх бололцоо их байдагтай холбоотой юм. Ерээд онд бараг үзэгдэхээ больсон сэтгүүл сүүлийн жилүүдэд тогтвортой өсч байна. 2008 онд Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн мониторингийн судалгаагаар улсын хэмжээнд 46 сэтгүүл бүртгэгдэж байсан бол, 2010 онд 65 болж өссөн баримтаар дээрх дүгнэлтийг баталж болно. Өнөөдөр гарч байгаа сэтгүүлүүдийг гарах давамгаар нь долоо хоног тутмын, 10-14 хоног тутмын, сар тутмын, хоёр сар тутмын, улирал тутмын хэмээн ангилж болох бөгөөд, эдгээрийн дотор сар тутмын сэтгүүлийн тоо бүх сэтгүүлийн 50,0 орчим хувийг, борлуулалтын 45,0 хувийг тус тус эзэлж байгаа юм. Харин долоо хоног тутмын сэтгүүл нийт сэтгүүлийн 10,5 хувийг, борлуулалтын 25,2 хувийг эзэлж байгаагаас үзвэл өнөөгийн

нөхцөлд долоо хоногийн хийгээд сар тутмын сэтгүүлүүд илүү эрэлттэй, бас ирээдүйтэй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Өнөөдөр тогтвортой гарч байгаа сэтгүүлүүдийг соён гэгээрүүлэх чиглэлийг дагнасан буюу түлхүү барьсан сэтгүүлүүд, соён гэгээрүүлэх нийтлэл бүхий сэтгүүлүүд гэсэн хоёр хэсэгт ангилан үзэж болно. Эхний хэсэгт «Шинжлэх ухаан, амьдрал», «Монгол хэл, соёл», «Шинжлэх ухааны академийн мэдээ», «History of Mongolia» (Монголын түүх), «Компьютер таймс», «Танд хэрэгтэй», «Миний компьютер», «Sunny MONGOLIA today» (Нарлаг Монголын өнөөдөр), «Өрхийн үйлдвэрлэл», «Та чадна», «Алтан гадас», «Менежер»,

«

Сэтгүүлийн соён гэгээрүүлэх шинж сониныхоос давуу байдаг нь өдөр бүр гардаггүй учир байгал нийгмийн үзэгдэл, үйл явдлыг тал бүрээс нь ул суурьтай судалж, гүнзгий дүгнэлт хийх бололцоо их байдагтай холбоотой юм

»

«Байгал орчин», «Горилогч», «Ногоон эрэл», «Нэмэлт цаг» зэрэг сэтгүүлээс гадна хүүхдийн болон мэргэжлийн сэтгүүлүүдийг хамруулан авч үзлээ. Учир нь «Цондоолой, Цүндээлэй», «Динза», «Нар», «Миний анхны зураг толь» зэрэг сэтгүүлүүд хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлж, шинэ мэдлэг өгч, зөв хүмүүжүүлэхэд чиглэсэн танин мэдэхүйн шинжтэй нийтлэлийг түлхүү гаргадаг байна. Түүнчилэн «Моторын эргэлт», «Барилга. МН», «Спортын цонх», «Сэтгүүлч», «Аялал», «Анагаах арга барил», «Эрүүл мэнд, инээмсэглэл», «E Doktor» (Электрон эмч), «Маркетинг» зэрэг сэтгүүлд тухайн салбарын шинжлэх ухааны ололт амжилт, шинэ технологи, ажлын дэвшилт арга барилыг тусгадгаараа соён гэгээрүүлэх шинж давамгайлж байна.

Бидний ангиллын хоёр дахь хэсэг буюу соён гэгээрүүлэх нийтлэл бүхий сэтгүүлд «Ирмүүн life» (Ирмүүн амьдрал), «Гоодаль», «UPTOWN» (Баячуудын хороолол), «Гялбаа», «Хийморьлог эрчүүд», «Business MAN», «Business LADY», «Гранд», «Тэнхлэг зууч», «INFO TV» (TV мэдээлэл), «TV ZONE» (TV чөлөөт бүс), «TV WEEKEND» (TV амралт), «Соронз», «Зэрлэг алим», «Step ба Step» (Алхам алхмаар), «Royal time» (Сонгодог цар), «ELLE», «KISS» (Үнсэлт), «Тойм», «Хүмүүний амьдрал», «Үндэсний тойм» зэрэг гуч гаруй сэтгүүл багтаж байна.

Үүссэн цагаасаа хойш аль ч үед Монголын сэтгүүлүүдийн соён гэгээрүүлэх чиглэлийн тэргүүнд явж ирсэн хэвлэл бол «Шинжлэх ухаан, амьдрал» сэтгүүл юм. Тус сэтгүүл анх 1935 онд «Шинэ толь» нэртэйгээр гарч эхэлсэн бөгөөд 1941 оноос «Шинжлэх ухаан», 1957 оноос «Шинжлэх ухаан, техник», 1960 оноос «Шинжлэх ухаан», 1965 оноос «Шинжлэх ухаан, амьдрал» нэрээр гарч байснаа ерээд оноос хэсэг хугацаанд завсарлаад 2009 оноос дахин гарч эхэлжээ. Уг сэтгүүл орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилт, нэрт эрдэмтдийн бүтээл туурвил, залуу судлаачдын шинэ соргог санаа сэдэл, Монголын болон дэлхийн шинжлэх ухааны өмнө тулгарч байгаа асуудлууд гэх мэт өргөн цар хүрээтэй сэдвээр бичдэг бөгөөд тэдгээрийг «Шинжлэх ухаан, үйлдвэрлэл», «Эрдэмтэн», «Гүн ухаан, сэтгэлгээ», «Судалгаа», «Асуудал», «Хэл, соёл урлаг», «Монгол мэдлэг, уламжлал», «Үйл явдал» гэх мэт тогтмол буланд төрөлжүүлэн нийтэлдэг байна.

«Шинжлэх ухаан, амьдрал» сэтгүүлийн 2010 оны №2 (312) дугаарын «Эрдэмтэн» буланд ахмад судлаач О. Намнандоржийн эрдэм шинжилгээний

бүтээлийн тоймыг танилцуулж, «Орчлон ертөнцийн байлдан дагуулалт» гэдэг өгүүллийг нь нийтэлжээ. Уг өгүүлэлд бидний аж төрж буй дэлхий, бүх орчлонт ертөнц хэрхэн оршдог хийгээд тэдгээрийн хоорондын зай, түүнийг хэмжих "гэрлийн жил" гэдэг ойлголтыг тайлбарласан юм. Зохиогч «Нарны аймгийн хамгийн хол орших гариг Дэлхийн Ван хүртэл зургаан миллиард километр болох, энэ нь асар хол юм шиг боловч нарны аймагт хамгийн ойрхон орших одонг хүртлэх зайг бодвол юу ч биш юм. Хэрэв нарыг энэ байгаагаас цааш 100 мянга дахин холтговол тийм жижиг одон болж үзэгдэнэ. Нарны аймагт хамгийн ойр орших Альф Центавр гэдэг одыг хүртэл дөчин саян сая (4-ийн ард 13 тэгтэй тоо – Н. А.) километр юм. Тийм холыг километр болгоход маш түвэгтэй билээ. Иймд одон орон ба орчлонт ертөнцийн хоорондох зайг хэмжихэд метр ба километрийн зэрэг ямар ч хэмжээс огт тохиромжгүй болох тул хялбар дөхмийг бодож тийм их холыг "гэрлийн жил" гэдэг аргаар хэмжих болжээ. Гэрэл нэг секундэд 300. 000 километр ба нэг жилд арван саян сая (1-ийн ард 13 тэгтэй тоо – Н. А.) километр орчим явна. Иймд наранд хамгийн ойрхон одон эндээс дөчин саян сая километр хол юм гэж байснаас дөрвөн гэрлийн жилийн зайтай юм гэвэл ойлгоход хялбар болно. Гэрэл нь 40 мянга гаруй километрийн бүслүүртэй манай дэлхийг нэг секундын дотор долоо дахин орооно» гэх мэтээр бичсэн байна.

Соён гэгээрүүлэх нийтлэлд хоёр үндсэн шаардлага тавигддаг. Тэр нь нэгд: хүнд шинэ мэдлэг, ойлголт өгч байх, хоёрт: тэр мэдлэгийг нийтэд ойлгогдохоор хялбаршуулж тайлбарлах шаардлага юм. Дээрх

өгүүлээс хэдхэн өгүүлбэрийг иш татахад энэ шаардлагыг бүрэн хангасан нь илэрхий байна. «Улс төр, хов жив, элдэв шуугианаас ангид, танин мэдэхүйн мэдээллүүд, шинжлэх ухаан, технологийн ололтуудыг танилцуулах» зорилготой сэтгүүлийн нэг нь «Алтангадас» юм. Үүссэнээсээ хойш 80 гаруй дугаар гаргаад байгаа тус сэтгүүлийн 2010 оны №8 (80) дугаарт л гэхэд «400 сая хүн испани хэлээр ярьдаг», «Адал явдал хайгчдын зорих газар Непал», «Швейцарьт амьдралын өртөг өндөр», «Индонези улс 17508 арал эзэмшдэг», «Дэлхийн хамгийн том боомт, гурав дахь том хот Шанхай», «Унгар улс загасчлах аялаар жуулчдыг татдаг», «Узбекстан улс өөр хаана ч байхгүй, дуурайж боломгүй онцлогтой» гэх мэт гол төлөв гадаадын улс орнуудын хөгжил дэвшил, өвөрмөц онцлогийг харуулсан арав шахам өгүүлэл багтсан байна. Энэ дугаарын «Миний мэдэхгүй Монгол» буланд бидний өвөг дээдэс цаасан мөнгө болон хуурай сүүг анхлан бүтээж, амьдрал ахуйдаа ашиглаж байсан тухай өгүүлж, монгол ёс заншлыг залуу үед сонирхолтой хэлбэрээр өвлүүлэхэд чиглэсэн үгийн сүлжээ нийтэлсэн байна.

Түүнчилэн «Компьютер таймс» сэтгүүлийн 2010 оны №03 (40)-д нийтлэгдсэн «Ирээдүйн эмнэлгийн технологи», «Роботуудын тулаан», «Таблет компьютер 2010 оныг байлдан дагуулах уу?», «Panasonic корпораци», «Цэргийн хүчний шилдэг», «Радио давтамж, түүнийг юунд ашигладаг вэ?» гэх мэт өгүүлэл, зөвлөгөө, «Танд хэрэгтэй» сэтгүүлийн 2010 оны №10-д нийтлэгдсэн «Элэг, бодисын солилцооны лаборатори», «Үр тарианы ач тус», «Модны үндсийг хайрлавал илүү сайхан цэцэглэдэг», «Халзрал гэж

юу вэ?» гэх мэт ашигтай зөвлөгөө, «sunny MONGOLIA today» сэтгүүлийн 2010 оны №09-д нийтлэгдсэн «Их Монгол улс», «Бичиг соёлыг дэлгэрүүлэгч», «Хөгжлийн амин судас», «Монгол ардын», «Монгол ардын хөгжим», «Өмнө зүгт мордсон нь», «INFO TV» сэтгүүлийн 2009-2010 оны дугааруудад нийтлэгдсэн Монголын хаад [Лэгдэн (1604-1634), Баянмөнх (1452-1470), Зүчи (1184-1227), Боди-Алаг (1504-1547) гэх мэт]-ын амьдрал, тэмцлийн түүхийн цуврал өгүүлэл зэрэг уншигчдын оюун ухааныг тэлэхүйц оюунлаг нийтлэл олон гарчээ.

Соён гэгээрүүлэх шинжтэй сэтгүүлүүдийн дунд гоо зүй (20,7 хувь), бизнес, эдийн засаг (20,0 хувь)-ийн сэтгүүл зонхилох суурийг эзэлж, урлаг (10 хувь), эрүүл мэнд (9,8), боловсрол (9,5)-ын чиглэлтэй сэтгүүл удаалж байна. Гэгээрүүлэгч шинжтэй сэтгүүлүүдийн дотор шинжлэх ухаан (4,0), боловсрол (9,5 хувь), уран зохиол (5,3)-ын сэтгүүл маш бага хувийг эзэлж байгаа нь анхаарал татсан үзүүлэлт юм. Дэлхий дахины соён гэгээрүүлэгчид шинжлэх ухааны мэдлэг түгээж, боловсрол олгох, уран зохиол дэлгэрүүлэх үйлсийг соён гэгээрүүлэх зорилтын төвд тавьж ирсэн уламжлалтай. Манай сэтгүүлүүдийн хүнд хэрэг болох мэдээлэл, гэгээлэг нийтлэлийн тоо хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь сайшаалтай боловч загварын ертөнц, гоо сайхны зөвлөгөө, эрүүл аж төрөх ёс, амралт зугаацал гэх мэт гол төлөв хүний өдөр тутмын хэрэгцээ, өнгөц сонирхолд нийцсэн асуудлын хүрээнд эргэлдэж, соён гэгээрүүлэх сонгодог чиглэл болох шинжлэх ухаан, боловсрол, уран зохиолын сэдэв харьцангуй бага тусгагдаж байгааг судалгааны дүн харууллаа. Энэ нь сонин, сэтгүүлийн

соён гэгээрүүлэх нийтлэлийн оюуны өгөөж хангалтгүй байгаагийн шинж юм.

Нийтлэлийн соён гэгээрүүлэх шинжийг сайжруулах зорилтыг дангаар нь, нэг далайлтаар шийдвэрлэх боломжгүй юм. Иймд нийтлэлийн чанарыг сайжруулах, тэр тусмаа соён гэгээрүүлэгч шинжийг гүнзгийрүүлэх зорилтыг цогцолбороор нь шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Миний бие энэхүү өгүүлэлд нийтлэлийн шинэчлэлийн цогц үйл ажиллагааны дараах загварыг санал болгож байна. Уг загвар **нэгд:** нийтлэлийн шинэчлэл, **хоёрт:** редакцийн үйл ажиллагааны шинэчлэл, **гуравт:** ур чадварын шинэчлэл гэсэн гурван зорилтыг багтааж байгаа бөгөөд, тэдгээр нь дотроо бүрдэл хэсгүүдтэй байх юм. Тухайлбал нийтлэлийн шинэчлэл нь юуны өмнө уламжлалт төрөл, зүйлүүдийг нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан сэргээж, нөлөөлөх чадварыг сайжруулах, амьдралаас урган гарсан буюу хөгжингүй орнуудын сэтгүүл зүйгээс орж ирсэн шинэ төрөл, зүйлүүдийг нийтлэлийн практикт нэвтрүүлэх, нийтлэл бүтээх үйл явцад уламжлал, шинэчлэлийг хослуулах гэсэн хэсгийг багтааж байгаа болно. Нийтлэлийн уламжлалт зүйлүүдийн зарим нь ардчилсан нийгмийн үзэл, үнэлэмжид тохирохоо больж ханшаа алдсан ч олонх нь эрэлт хэрэгцээтэй хэвээрээ байгаа юм. Харин тусгах объект, хэлбэр, өгүүлэх арга маягийг нь шинэчлэх шаардлагатай бөгөөд тийм шинэчлэл илт болж байгааг ч анзаарахгүй байх аргагүй. Жишээ нь хэвлэлийн тойм телевиз, радиод шилжсэн, найруулал хөрөгт төвлөрсөн, тайлан Их хурал, Засгийн газрын хуралдааны сурвалжлага болж хэлбэрээ өөрчилсөн гэх мэт олон жишээ дурдаж болно. Түүнчилэн дэлхий

дахины тогтмол хэвлэлд өргөн хэрэглэгддэг мөрдлөг, прогноз, туршилт, тайлбар, хувилбарт бодол зэрэг бичлэгийн зүйлүүдийг нийтлэлийн үйлсэд ашиглах бодит шаардлага гарч ирж байна. Уламжлал, шинэчлэлийг хослуулан туурвих боломж ч байна. Жишээ нь уламжлалт нийтлэлийн хэлбэрүүдийг шинэ агуулгыг илэрхийлэхэд ашиглах гэх мэт.

Соён гэгээрүүлэх нийтлэлийн тоо хэмжээ, үр нөлөөг сайжруулах зорилтыг тогтмол хэвлэлийн нийтлэлийн бодлого, менежментийг цогцоор нь сайжруулах ажлын хүрээнд л шийдвэрлэх боломжтой юм. Үүнд редакцийн үйл ажиллагааны шинэчлэл чухал үүрэгтэй. Энэ чиглэлийн шинэчлэлийг **нэгд:** редакцийн оновчтой бүтэц зохион байгуулалт, **хоёрт:** өөрийн хяналт, **гуравт:** редакцийн бүтээлч уур амьсгал, **дөрөвт:** урамшуулал зэрэг хөшүүргийг ашиглан хэрэгжүүлэх бололцоотой гэж үзэж байна. Нийтлэлийн соён гэгээрүүлэх үүргийг зөвхөн өдөр тутмын хэдэн сонинд үүрүүлэх нь хангалтгүй бөгөөд энэ нь тогтмол хэвлэл бүрийн зайлшгүй анхаарч тусгах ёстой асуудал мөн. Өнөөдөр нийгэм-улс төрийн үндэсний хэмжээний томоохон сонинуудын Соёл урлагийн албыг эс тооцвол редакцийн бүтцэд соён гэгээрүүлэх чиглэлийг дагнасан алба, хэлтэс үгүй байна. Чөлөөт хэвлэлүүдэд соён гэгээрүүлэх үүрэг, булан үгүйлэгдсээр байна. Энэ нь оюунлаг нийтлэлийг бүрэлдэхүүндээ багтаасан стратегийн бодлогыг тогтмол хэвлэл бүрийн редакцид хэвшүүлэх шаардлагатайг харуулж байгаа юм.

Өнөө үед нийтлэлийн бодлого, үйл ажиллагааг хамтын оюун ухаанаар тодорхойлж, сэтгүүлчийн ур чадвар, ёс зүйг үнэлж дүгнэдэг редакцийн өөрийн

хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна. Олонх редакцид нийтлэлийн нэгдсэн бодлого дутагдаж, хүн бүр тохиолдлын чанартай баримтаар бичиж туурвиж байгаагаас нийтлэл урсгал шинжтэй болох явдал арилахгүй байна. Редакциуд сэтгүүлч, уран бүтээлчдийн идэвхийг урамшууллын хөшүүргээр өдөөх явдал хангалтгүй байна. Олонх редакци их бичсэнийг урамшуулдаг атлаа сайн бичсэнийг үнэлэх механизмгүй байна. Жишээ нь хүн бүрт сонины нэг буюу түүнээс олон нүүрийг хариуцуулдагас сэтгүүлчдийг зай бөглөх уралдаанд гүйх гэмд хүргэжээ. Хуучин тогтолцооны үед доголдож байгаа сэдэв, төрөл зүйлээр уран бүтээлийн уралдаан зарлан дүгнэдэг байсан уламжлал тасарсан байна. «Их говийн зоригтон хүмүүс», «Талын шуурга», «Өвлийн нүүдэл» гэх мэт алдартай найрууллууд гагцхүү уралдаанаар төрснийг бид мэднэ.

Редакцийн үйл ажиллагааг шинэчлэхэд сэтгүүлчдийн дунд бүтээлч, эвсэг уур амьсгал бүрдүүлэх явдал чухал байдаг. Хорь, гучаад оны зохиолчид тойрч суугаад шүлгийг мөр мөрөөр нь элбэж бүтээдэг байсан, дал наяд оны радиогийн сэтгүүлчид бие биеийнхээ бүтээсэн нийтлэл, нэвтрүүлгийг шүүн хэлэлцэж, үнэлж цэгнэдэг «Улаан харандаа» хэмээх ханын сонин гаргадаг байсан зэрэг бүтээлч уур амьсгал, хамтын ажиллагааны шилдэг жишээ олон бий. Тэр уламжлалыг сэргээхэд болохгүй зүйл байхгүй. Ялангуяа редакцийн ахмад үеийнхэн туршлагаа, залуу үеийнхэн мэдлэгээ харилцан солилцож, нэгдмэл арга барил, ур чадварыг бүтээх хэрэгтэй байна.

Нийтлэлийн шинэчлэлийн загварын гурав дахь хэсэгт ур чадварын

шинэчлэлийг авч үзлээ. Энэ нь нэгд: сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадвар, **хоёрт:** редакцийн удирдагч ба сэтгүүлчдийн онол, улс төрийн мэдлэг, **гуравт:** редакцийн алба, хэлтсүүдийн хамтын ажиллагаа, **дөрөвт:** нийтлэлийн бодлого, төлөвлөлт гэсэн бүрдэл хэсгүүдийг багтаана. Сэтгүүлчдийн ур чадвар гэдэг өргөн ойлголт бөгөөд ганц редакцийн менежментээр шийдвэрлэх асуудал биш юм. Энэ нь сургалтын байгууллага, дипломын дараах болон мэргэших сургалт, редакцид олж авах дадлага туршлага гэх мэт олон хүчин зүйлийн хамсал байдлаар шийдэх асуудал мөн. Нийтлэлийн соён гэгээрүүлэх шинж, оюунлаг чанарыг сайжруулахад редакцийн хамт олны удирдагчдын үүрэг асар их юм. Тогтмол хэвлэлийн ерөнхий эрхлэгч, редакторууд нь тухайн редакцийн бодлогыг тодорхойлогч стратегийн менежерүүд бөгөөд байгууллагын ололт амжилтын 77,0 хувь нь тэдний хөдөлмөр зүтгэлийн үр дүн байдаг гэж менежментийн ухаан сургадаг. Тэд бүтээл туурвил, онол, улс төрийн мэдлэгээрээ үлгэрлэн дагуулагч, сэтгүүлч хамт олны авьяас билгийг хөгжүүлэхийн төлөө тэмцэгч байх ёстой. Авьяас зөвхөн мэдлэг дээр суурилж хөгжин цэцэглэдэг. Мэдлэггүй авьяас бол хөөстэй адил юм.

Сайн нийтлэл төрөх бас нэг нөхцөл нь редакцийн алба, хэлтсүүдийн хамтын ажиллагаа, харилцан шүтэлцээ мөн. Тэдгээрийг хооронд нь харилцуулж, редакцийн нэгдмэл бодлогод зангидах, тэгснээрээ сонины дугаар бүрийг чиглэсэн зорилготой бэлтгэх явдал хангалтгүй байна. Энэ үүргийг хэрэгжүүлдэг чадварлаг нарийн бичгийн дарга ихээхэн үгүйлэгдэх болжээ. Алба, хэлтсийн дарга, эрхлэгчид өөр өөрсдийн нийтлэлийн бодлогыг

харилцан мэдээлж санал солилцох, уншигчдын эрэлт хэрэгцээг судалж тусгах явдал ч шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Нийтлэлийг урсгал байдлаас гаргаж, зорилго чиглэлтэй болгодог гол зүйл бол урт, богино хугацааны төлөвлөгөө байдаг. Сонин цаг үеийн толь байдаг тул өдөр тутмын амьдралыг тусгах нь зүйн хэрэг. Түүнтэй зэрэгцүүлэн өөрийн дүр төрхийг бүтээх, соён гэгээрүүлэх үүргээ хэрэгжүүлэх зорилтыг урьдчилан бодож боловсруулсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг байх учиртай. Олонх редакцид ийм бодлого, төлөвлөлт дутсанаас цаг хугацаа, үйл явдлын хойноос дагаж гэлдэрдэг идэвхигүй байдал ноёлох болсон нь өнөөгийн тогтмол хэвлэлийн нийтлэг дутагдлын нэг мөн.

Нийтлэлийн шинэчлэл гэдэг нь үзэгдэл, үйл явдлын нийгмийн ач холбогдлыг үнэлж цэгнэх, баримтыг зөв сонгож, боловсруулж, дүгнэлт гаргах, эх сурвалжид нэвтрэх, илэрхийлэх арга барилаа оновчтой тогтоох, үгийн урлагийг эзэмших гэх мэт олон чадварыг багтаасан цогц ойлголт юм. Эдгээрийн аль нэгийг дутуу анхаарсан үед нийтлэлийн үр нөлөө сулардаг. Манай сэтгүүлчдийн нийтлэг дутагдлын нэг нь мэдээллийн эх сурвалжид нэвтрэх чадахгүй байгаа явдал мөн. Ийм дутагдлын нэг хэсэг нь мэдээлэл олж авах аргаа олохгүй байгаатай, нөгөө хэсэг нь эрж сурахаас залхуурч таавраар бичдэгтэй холбоотой байна. Мэдээлэл эрж олох, эх сурвалжаа нууцларч эрх зүйн орчин бүрдээгүй байгаа хэдий ч энэ нь сэтгүүлчийн харилцаа, мэдээллийн сүлжээ, овсгоо самбаанаас ихээхэн шалтгаалах зүйл юм.

Сүүлийн жилүүдэд манай сэтгүүлчдийн дотор юмны ул мөрт орох, үйл

явдлын учир шалтгааныг мөрдөж мөшгөхийн оронд үзэл бодлоо бичих, түүнийгээ тулган хүлээлгэхийг оролдох хандлага ажиглагдах болов. Тэд ямар ч баримт ашиглахгүйгээр улс төр, нийгмийн үзэгдэл, үйл явдлыг «цээжний бан»-гаар үнэлж дүгнэдэг. Бүр «үзэл бодлын сэтгүүл зүй» гэдэг нэр томъёо хүртэл гараад ирсэн. Зүй нь үзэл бодлоо илэрхийлэх гэдэг нь сэтгүүлчээс илүүтэй иргэд, олон нийтэд хамаатай ойлголт юм. Тэд зөвхөн үзэл бодлоо илэрхийлдэг бол сэтгүүлч асуудлын гүнд орж, баримт нотолгоо бүрдүүлж, түүнийгээ үндэслэн үнэлэлт дүгнэлт гаргах ёстой.

Сэтгүүлч хүнд уран сайхны авьяасаас гадна, улс төрийн авьяас зайлшгүй чухал байдаг. Амьдралд болж байгаа өчүүхэн зүйлийг ч соргоогоор мэдэрч, түүнээсээ ургуулан нийгмийн ач холбогдол бүхий томоохон санаа, дүгнэлт гэржж чаддаг байх нь сэтгүүлчийн уран чадварын нэг илэрхийлэл мөн. Бид энэ талаар ахмад үеэсээ суралцах хэрэгтэй байна. Нэрт сэтгүүлч, авьяаслаг шог найруулалч Н. Иштавхай агсан насан туршдаа 2000 орчим шог найруулал бичжээ. Энэ нь төдий тооны буюу түүнээс ч олон хүнийг шүүмжилсэн гэсэн үг. Гэтэл зохиогчийн талаар нэг ч хүн гомдол мэдүүлж, шүүхэд заргалдаагүй байна. Үүний нууц нь бичсэн зүйлээ гарцаагүй баримтаар баталгаажуулдаг байжээ. Ганц жишээ татъя. «Тоншуул» сэтгүүлд «Сүхбаатар дүүргийн шүүгчид хэргийг шударга зөв шүүхгүй байна» гэсэн мэдээлэл ирсний дагуу Н. Иштавхай сурвалжлахаар очжээ. Хамт ажилладаг дөрвөн шүүгчийн нэгтэй ярилцахаар хүлээж суутал нээлттэй үүдээр нуруу нь бөгтийж, эрүү нь өвдөгтөө хүрсэн нэг эмгэн шагайж «Цэрэндолгор шүүгч хаана суудаг вэ?» гэж асуухад

зүй ерөнхийдөө хөгжлийн зөв голыг
ролд орсны илрэл мөн.

Ишлэл

- ¹ Прохоров Е. П. 1995. Введение в теорию журналистики. М., с. 63
- ² Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ., 80 дахь тал.
- ³ Наранбаатар Б. 2008. Монголын цахим сэтгүүл зүйн хөгжил, хандлага тулгамдсан асуудлууд. МУИС-ийн ЭШД (Сэтгүүл зүй). УБ., 86 дахь тал
- ⁴ Ариунзаяа Н. 2014. Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж. УБ., 17 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Прохоров Е. П. 1995. Введение в теорию журналистики. М.
2. Горохов В. М. 1982. Слагаемые мастерства. М.
3. Теплюк В. М. 1984. Социальная ответственность журналиста. М.
4. Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.
5. Наранбаатар Б. 2008. Монголын цахим сэтгүүл зүйн хөгжил, хандлага тулгамдсан асуудлууд. МУИС-ийн ЭШД (Сэтгүүл зүй). УБ., № 08 (293).
6. Ариунзаяа Н. 2014. Монголын нийтлэлийн соён гэгээрүүлэгч шинж. УБ.
7. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм (Тэргүүн дэвтэр) УБ.
8. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл (Тэргүүн боть). УБ.

Summary

This article analyzed enlightens characteristics of Mongolian modern periodicals based on published articles at the main newspapers and journals. Based on research study, the article proposes three joint directions in compressive sensing, which are publicity, newsroom, and skills to enhance enlighten characteristics in periodical discourse.

шүүгчдийн хэн нь ч тэр эмгэн рүү харсангүй мөртөө нэг нь «Дээрээ байгаа хаягийг харахгүй юу» гэж хайнгадуухан дуугарчээ. Хэрэв тэдний аль нэг нь эмгэн рүү харсан бол дээрх хаягийг байтугай урдах замаа ч алсхан харахгүй хүн болохыг нь мэдэх учиртай байв. Н. Иштавхай эндээс л шог найрууллынхаа санааг олчихсон байна. Тэр нь хүний хувь заяаг шийддэг хүмүүс юманд ийм хайнга хандаж болохгүй гэсэн санаа байжээ. Энэ мэтээр асуудалд мэдрэмжтэй хандаж, ургуулан бодож, няхуур нямбай боловсруулах аргад залуу сэтгүүлчид хангалтгүй суралцаж байна.

Улс төрийн янз бүрийн нам, хүчин, бизнесийн бүлэглэл, нийгмийн болон сонирхлын бүлэг, хэсгүүд, чөлөөт иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлсэн өөр өөр үзэл бодол, өнгө аястай мэдээллийн хэрэгслүүд зэрэгцэн оршиж, зах зээлд өрсөлддөг ардчилсан нийгмийн жишгээс Монголын сэтгүүл зүй тойроогүй юм. Сэтгүүл зүйд гарсан эрс өөрчлөлт нь бүхэлдээ хүн төрөлхтний хөгжил дэвшил, тэргүүний сэтгэлгээнд дөтөлсөн түүхэн ололт болсон хэдий ч шилжилтийн хүнд бэрх замыг туулах явцдаа амжилт ололт, алдаа эндэгдлийн аль алиныг дагуулсан нь тодорхой билээ. Гэвч тогтмол хэвлэлийн нийтлэл улс орны эрх ашгийг дээдлэн, асуудалд голч шударга хандаж, аливаа хийрхэл туйлшрал, цуурхал гүтгэлгээс алгуур ангижирч, ямар ч асуудалд улс орны эрх ашгийг дээдлэн, голч байр сууринаас ханддаг болох тийш улам бүр ахисаар байгаа нь эерэг үзүүлэлт төдийгүй, ардчилсан нийгмийн сэтгүүл